

“ИДЭЭ УНДААНЫ ЖИНХЭНЭ ТОВЧ” ЗОХИОЛЫГ “ХУБИЛАЙН ИДЭЭ УНДААНЫ ЖИНХЭНЭ ТОВЧ” ХЭМЭЭН НЭРЛЭСЭН УЧРЫГ ТАЙЛБАРЛАХ НЬ

Нандинцэцэг Д.¹, Сумъяахорол Г.², Бао Ан², Улаан-Од Х.², Наранзаяа Л.², Болд Ш.³

¹“Эмзүйн шинжлэх ухааны их сургууль”, ²“Ач” Анагаах ухааны их сургууль, ³“Монголын анагаах ухааны академи”

Email: nandiarose50@gmail.com

EXPLANATION OF THE REASON OF “FUNDAMENTAL PRINCIPLES OF FOOD AND DRINK” WAS CALLED THE “KHUBLAI’S FUNDAMENTAL PRINCIPLES OF FOOD AND DRINK”

Nandintsetseg D.¹, Sumiyakhrol G.², Bao an², Ulaan-Od Kh.², Naranzaya L.², Bold Sh.³

¹Mongolian University of Pharmaceutical Sciences, ²“Ach” Medical University, ³Mongolian Academy of Medical Science

ABSTRACT

Introduction

In “Bencao gangmu” (李时珍本草纲目 Compendium of Materia Medica) written by Li Shizhen in 1590 mentioned that “Khublai’s Fundamental Principles of food and Drink” (忽必烈飲膳正要) instead of “Fundamental Principles of Food and Drink” by Khusekhui. “Compendium of Materia Medica” is an encyclopedic work on traditional Chinese materia medica before the 16th century. It was compiled and written by Li Shizhen (1518-1593), a medical expert of the Ming Dynasty (1368-1644). The compendium is the most complete and comprehensive medical book ever written in the history of Traditional Chinese medicine. It has been translated, totally and partially, in more than 20 foreign languages, including Japanese, Korean, Latin, French, German, English, Russian, etc. It has been reprinted over 100 times in the past 400 years and is still used by scientists, professionals, and practitioners of the fields as a monumental reference work. Why was famous herbalist Li Shizhen highlighted “Khublai’s Fundamental Principles of Food and Drink”? Based on the “Bencao gangmu”, the title of the book was “Fundamental Principles of Food and Drink”, but its popular name was “Khublai’s Fundamental Principles of Food and Drink”.

Methods: We used following study methods; manuscripts, primary source methods, hermeneutic method, analysis-synthesis method.

Results: According to the general content of the foreword by Minister Yuji and Khushui (Hushui), the “Fundamental Principles of the Food and Drink” is not a newly developed work. Khublai Khan provided the motivation and basis for compiling this book.

Conclusion: “Fundamental Principles of the Food and Drink” is based on the use of herbal medicine and food that was founded by Khublai Khan and evaluated and selected and the actual consumption of the food and drink of eight Mongolian Khans from Khublai (1260-1294) to Zayat Khan (1328-1332). Before Husehui’s book “Fundamental Principles of the Food and Drink” was published, some information related to Mongolian food and drink can be found in the “Secret history of the Mongols”.

Key words: Khublai Khan, Fundamental Principles of the Food and Drink, Bencao gangmu

ҮНДЭСЛЭЛ

Алтан ургийн Тулуйн хүү Хубилай 1271 онд Юань гүрнийг байгуулав. Хубилай хаан их Юань улсыг байгуулсны дараа нийгмийн бүхий л салбарыг хөгжүүлэхийг зорьж байсны дотор эрүүл мэндийн тогтолцоо онцгой байранд тавигдаж байжээ. 1260 онд Тай И Юан гэх эм эмнэлгийн захиргааны газрыг

байгуулан мөнгөн тамга өгч эм, эмнэлгийн хэрэг явдлыг шийдэх, эмт бодисыг өргөн барих, эмийн хорооны эмч нарыг захирах зэрэг хэрэг явдлуудыг эрхлүүлсэн байна. 1269 онд эм барих түшмэлийг томилон эл газар орноос ирсэн ховор эм, эрдэнийн эм ба өвсөн эмийг хариуцуулах, эм тан үйлдэх

явдлыг хамааруулсан байна. Юань гүрэн нь дэлхийн хуурай газрын тавны нэгийг өөрийн болгон захирч байв. Эл өргөн уудам газар нутгийн үндэстэн ястан бүрийн хоол унд, идээ зоогийн соёл нэн арван бөгөөд өөр өөр байсан нь лавтай. Тийм ч учраас номын зохиогч Хүсэхүйн бичсэн өмнөх үгэнд “Дээд эзэн хааныг өвчингүй эрүүл биед сэргийлэн асрахыг анхаарахаас бус, өвчилсөн хойнох явдлаар голчлохгүй байх нь идээ ундааны жинхэнэ ёсыг хүндэтгэж, эм ерөндгийг дээдэд мэдүүлсэн санаа ажгуу. Тиймийн тул ерийн үгэнд “Хоолны нарийлгаас халшрах үгүй. Махны тарганаас уйдах үгүй” хэмээн өгүүлсэн нь даруй энэ болой” гэж бичсэн нь номын гол ач холбогдлыг илэрхийлэхээс гадна, чанар сайтай харь газрын тансаг хоолноос халшрахгүй, өөрсдийн идэж заншсан тарган махнаас ч уйдахгүй гэсэн жинхэнэ монгол хэрэглээг шигтгэсэн зүйр үгийг оруулж өгчээ. Энэ нь “Идээ ундааны жинхэнэ товч” ном нь монгол ахуй, монгол идээ, ундааны хэрэглээнд тулгуурлан бусад орны зохимжтой хоол хүнсний зүйлээр баяжуулан монгол хүний хятад хэлээр бичсэн зохиол мөн юм[1] гэснийг батлан илэрхийлж байна.

Хүсэхүйн бичсэн “Идээ ундааны жинхэнэ товч” номыг Ли Шижэн (1518-1593) – ий “Bencao Gangmu” (李时珍本草纲目) бүтээлд “Хубилайн идээ ундааны жинхэнэ товч” (Hubilie yinshan zhengyao-忽必烈飲膳正要) гэж бас нэрлэсэн байдаг. Ли Шижэний “Bencao Gangmu” нь монгол хэлээр “Эмийн материал судлалын эмхэтгэл” гэж орчуулагдана. 1590 онд хэвлэгдсэн энэхүү эмхэтгэл нь эмийн үйлдэлтэй ургамал, амьтан, эрдсийн гаралтай түүхий эд болон бусад эм, эмийн жоруудыг багтааж тайлбарласан, 16-р зуунаас өмнөх Зүүн Азийн эм зүй, эм судлалын ололт амжилт, хөгжлийг илтгэсэн, алдаа оноог дэнсэлсэн, буруу зөрүү ойлголтыг засаж сайжруулсан гол гарын авлага, орчин үеийн уламжлалт эм зүй, эм судлалын судалгааны эхийг тавьсан гайхамшигтай бүтээл юм. Мэдэхгүй эм зүйч, судлаач олон улсад байхгүй гэж хэлцдэг. Ийм бүтээлд “бисда” гэдэг жимсний тайлбарыг

“Хубилайн идээ ундааны жинхэнэ товч номоос авлаа” хэмээн онцлон тэмдэглэжээ. Яагаад алдарт Ли Шижэн, Хүсэхүйн “Идээ ундааны жинхэнэ товч” – ийг “Хубилай” – н хэмээн нэрлэв. Чухамдаа номын бичигдсэн нэр нь “Идээ ундааны жинхэнэ товч”, алдаршсан нэр нь “Хубилайн идээ ундааны жинхэнэ товч” байжээ хэмээн шууд хэлж болно[1].

ЗОРИЛГО

“Идээ ундааны жинхэнэ товч” зохиолыг “Хубилайн идээ ундааны жинхэнэ товч” хэмээн нэрлэсэн учрыг тайлбарлах

СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГАЗҮЙ

Судалгааны ажлын материал, эх хэрэглэгдэхүүн: “Идээ ундааны жинхэнэ товч” 1330 он (飲膳正要) – академич Ш.Болд, анагаах ухааны доктор, профессор Х.Улаан-Од нарын хятад хэлнээс шинэ монгол үсэг рүү орчуулан гаргасан хэвлэл. Улаанбаатар, 2022 он.

Судалгааны арга: бид энэхүү судалгаандаа эх бичиг, сурвалж бичиг судлалын арга; герменевтик арга; анализ синтезийн аргуудыг ашиглалаа.

ҮР ДҮН

Академич Ш.Болд, анагаах ухааны доктор, профессор Х.Улаан-Од нарын орчуулсан хэвлэлээс үзэхэд “Идээ ундааны жинхэнэ товч” зохиолд Хүсэхүй эмч өөрөө болон, ухуулах өргөмжлөлийг мэдэгч, түүх найруулагч сайд Юү Жи (虞集)(1272-1348), Мин улсын долоо дахь хаан Жинтай (景泰帝) (1449-1457) нар оршил бичсэн байдаг. Хүсэхүй өмнөх үгэндээ “Хичээнгүйлэн санаваас Тэнгэрийн хүү Хубилай хаан мэргэнээр тольдон харж эртний Жоу-Ли-гийн Тяньгуаны (周礼天官) ёслолын ноёд, захиргааны дүрмийг журамлан, тэргүүлэгч эмч, зоогийг хамаарагч эмч, дотор өвчнийг анагаагч эмч, шархны эмч зэргийг томилж тохируулаад, тэд тус бүрийн үүрэг тушаалаа гүйцэтгэж, тогтоосон хэв дүрмийг сахиж хэрэгжүүлж байв... Чиюүн хас, Рани, Басбүрү, Онбой зэрэг ширгээмэл ханд, үхрийн ясны чөмөг, Панмайнбрайбугийн шөл хийгээд

элдэв зүйлийн эрхэм дээд идээ зоогийг бүгдийг нь тохиромжтойгоор гүйцэтгэсэн. Иймээс Тэнгэрийн хүү Хубилай хааны насан хутаг батжин элдэв өвчин эмгэггүй эрүүл энх аж төрөв”[2] хэмээн тэмдэглээд цаашид эзэн хааны хөвгүүд ч бас анхаарч хичээх нь зүй гэсэн санааг илэрхийлсэн байдаг. Харин сайд Юүжи өмнөх үгэндээ “Эрт цагт Хубилай хаан өвсөн эмийн аргыг нягталж, идээ ундааг тохируулан, явах суухыг ёс дүрэмд нийцүүлсэн учраас бие лагшин урт насалж, үр хүүхдэдээ хязгаарлашгүй буян хишгийг хүртээсэн бөлгөө. Энэ ном бол тухайн үеийн дээд эрдэмтэн эмчийн өгүүлэл зохиол мөн хэмээсэн ажээ. Иймээс ном өргөгч нь мэргэжлийг үнэхээр уран хэрэгжүүлж үнэнч шударгаар гүйцэтгэж чаджээ” хэмээгээд энэхүү номыг каталла модоор сийлбэрлэн олноо тараа гэсэн хатан эхийн санааг уламжилжээ. Эдгээрээс улбаалан бодоход энэ номыг эмхэтгэн бичих сэдэл, уг сурвалж үндсийг Хубилай хаан тавьж өгчээ гэдэг нь ойлгомжтой байна. Юү жи сайд өмнөх үгийн төгсгөлдөө номын ач тусыг нэгэн түшмэл эсвэл сайдын мэдлийн хүрээнээс хальсан, тэдний зиндаанд зүйрлэж эс болох номын ач тусыг айхтар гүн агуулгатай үгээр “Тус бичгийг ухуулан дэлгэрүүлэх нь дэлхий дахины хойч үеийн хүмүүс, өнөөгийн төрийн дээд мэргэд зузаан хишгийг дурсан мэдэхийг бас юун өгүүлэх буй”[2] гэж жаргаасан нь хааны зиндааны л хүн хэлж чадах үг болох нь тодорхой байна.

Аливаа сайн бүтээл түүхэн номуудыг хааны нэрээр, арш мэргэдийн нэрээр нэрлэж алдаршуулах уламжлал Дорно дахинд түгээмэл байсан.

Вед нь манай гариг дээрх хамгийн эртний бичмэл бүтээл юм. Барагцаалбал Энэтхэгийн соёл иргэншил, Арийн соёлын эхэн үеэс үүссэн байна. Эхлээд ам дамжин хэлэгдэж шашны агуулга багатай, ардын аман зохиолын шинжтэй байсан мэдлэгийн дамжлагууд хожим нь 4000-6000 жилийн өмнөөс бичмэл хэлбэртэй, шашны болон гүн ухааны агуулгатай, олон үеийн сэтгэгчдийн бүтээл туурвилын эмхэтгэл болжээ. Анх амаар дамжин уламжлагдаж

байсан энэ эмхэтгэлийг Krishna Dvaipayana гэдэг мэргэн арш бичиг үсгэнд буулган 4 Вед шаштир болгон эмхэтгэсэн учраас түүнийг Вед Вьяса буюу Ведийн судлаач, эмхэтгэгч хэмээн өргөмжилж түүнээс хойш энэ нэрээр мөнхөрсөн байдаг.

Хятадад ч нэн эртнээс хааны нэрээр номыг нэрлэх явдал уламжлагджээ. Жишээ нь алдарт Хуанди – Нейжин 黄帝内经 байна. Энэ бүтээлийн нэрийг монголоор орчуулбал “Шар хааны анагаах ухааны дотоод жаяг” гэж бууна. “Дөрвөн судар”-ыг “Хааны дөрвөн судар” 黄帝四经 (Huangdi sijing), “Хааны бэрх судар” 黄帝八十一难经 (Huangdi ba shi yi nan jing), “Шүн зон хааны бодит тэмдэглэл” 顺宗实录 (Shunzong shilu), “Тай зон хааны бодит тэмдэглэл” 太宗实录 (Tai zong shi lu) зэрэг олон жишээ байна. “Тай зон хааны бодит тэмдэглэл”-ийн жинхэнэ нэр нь “Бодит тэмдэглэл” 实录 (Shi lu) гэж нэрлэдэг. Гэвч Тайзон хааны нэрийг оруулан “Тай зон хааны бодит тэмдэглэл” гэдгээрээ алдаршжээ. Энэ уламжлалыг баримтлан “Идээ ундааны жинхэнэ товч” номыг “Хубилайн идээ ундааны жинхэнэ товч” (Hubilie yinshan zhengyao -忽必烈飲膳正要) гэж нэрлэсэн байж болох юм.

Эртний Энэтхэг, Хятад, Төвөд зэрэг орнуудад аливаа номын нэрийн утгыг алдагдуулахгүйгээр салаа утга гарган хэрэглэж хүч оруулж алдаршуулах явдал олонтоо байжээ. “Рашааны гишүүн найман гишүүнт нууц удисын үндэс хэмээх оршвой” судрын нийтэд түгж алдаршсан нэр нь “Дөрвөн үндэс”. “Анагаах ухааны дөрвөн үндэс” гэдэг. Чухамдаа үндсэн гарчгийг нь бодитойгоор хувиргасан боловч агуулгын илэрхийлэл, ухагдахууныг нь өөрчлөлгүйгээр харьцааг нь хадгалж чадсан “Анагаах ухааны дөрвөн үндэс” гэсэн нэр өгч энэ нэрээрээ хэдэн зууны турш алдаршин өнөө ч хэрэглэсээр байна. Хожим ч ном судрын бүтэн нэрийг товч эсвэл тодорхой болгон салмал утгаар нэрлэх явдал өргөн дэлгэр тархжээ. Жишээ нь Чойнпил тойны “Эмийн гол судруудаас өвчний шинж, засал тэргүүтэн хэсэг бусаг гарсныг нэгэн зүгт эмхэлж энхрийлэн хураасан зүрхний эрдэнэ хэмээх оршвой” гэдэг алдартай судар

бий. Товчлоод “Энхрийлэн хураасан зүрхний эрдэнэ”, “Нандин эрдэнийн шимийн хураангуй” гэж нэрлэдэг. Гэвч энэ номын алдаршсан чухам нэр нь “Хар морьтын жор” хэмээдэг. Учир нь “Хар морьт” гэж олноо хүндлэгдсэн нэгэн эмчийн удирдлагаар Их хүрээний Мамба дацангийн багш нар санаа нэгдэн төвөд хэлээр бичиж дотнын анд нөхөр Лувсанчойнпил тойны алдрыг өргөмжлөн мөнхжүүлэх зорилгоор түүний нэрээр туурвисан гэдэг аман яриа бий. Хэдийгээр зохиогч нь Лувсанчоймпил тойн гэдэг боловч “Хар морьтын жор”-ын судар гэдгээрээ нийтийн сонорт хүрч, уг нэрээр түүхэнд үлдсэн байдаг.

Өөр нэгэн чухал жишээ бол Доминик Пареннины франц хэлнээс манж хэлээр орчуулсан “Дээрээс тогтоосон дүрсийг тус бүрийг бүртгэсэн бичиг” ном юм. Энэ номын 1723 онд орчуулагдсан нэгэн эх бичгийн нэр нь “Дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” гэдэг. Гэвч Манжийн хаан Энх-Амгалангийн зарлигаар орчуулж эхэлсэн хийгээд манж хэлний орчуулга бүрийг хянаж байсан Энх-Амгалан хааны зарлиг, алдар нэр хүндийг багтаасан “Дээрээс тогтоосон” гэдэг үгийг өөр нэгэн орчуулгын эхэнд оруулж өгсөн байдаг. Тиймээс “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” гэдэг нэрээрээ Монгол улсад анагаах ухааны түүх, сурвалж бичиг судлаачдад танил болсон. Гэтэл 20-р зууны дунд үеэс олон улсад “Манж анатоми” (Manchu anatomy) гэдэг нэрээр алдаршиж, одоо нэгэнтээ манж судлаач, хүний биеийн бүтэц зүйн эртний номыг судлаачид энэ нэрээр нь таних болжээ. Бид ч “Манж анатоми” гэдэг нэрээр нь бүтээлдээ бичиж эхлээд байна. “Идээ ундааны жинхэнэ товч” номыг “Хубилайн идээ ундааны жинхэнэ товч” хэмээн дуудах болсноор дээр дурдсан судалгааны үр дүнтэй агаар нэгэн буюу бодит нэр нь хувирах боловч агуулга, ухагдахууныг өөрчлөхгүйгээр зүйрлэх, солих, төлөөлөх аргаар салмал утга бүхий “Хубилайн идээ ундааны жинхэнэ товч” гэсэн нэр өгч уг нэрээрээ алдаршиж байжээ. Энэ нэрийг Ли Шижэн “Венсао gangmu” номдоо 1590 онд онцлон тэмдэглэж

үлдээсэн нь эх түүхээ бодит эх сурвалжид үндэслэн тодруулах, бичих, дүгнэхэд чухал ач холбогдолтой баримт нотолгоо болжээ.

ХЭЛЦЭМЖ

Хүсэхүй зоогийн эмч бээр Хубилай сэцэн хааны (1260-1294) үеэс Төвтөмөр буюу Заяат хааныг (1328-1332 он) хүртэлх Монгол хаадын идээ ундааны уламжлалыг судлан гаргасны үндсэн дээр 1330 онд Монгол хаадын идээ ундааны жор найрлагыг эмхэтгэн нэгтгэж “Идээ ундааны жинхэнэ товч” хэмээх алдарт зохиолоо бичжээ. Хүсэхүйн “Идээ ундааны жинхэнэ товч” номыг хэвлэгдэхээс урьд хожид монголчуудын идээ ундаатай холбоотой зарим мэдээллийг “Монголын нууц товчоо”-ноос олж үзэж болно.[3]

“Идээ ундааны жинхэнэ товч” нь 1330 оны эхээр барлагдан хэвлэгдсэн түүхтэй. Юань улсын үед Жао үсгийн хэлбэрээр бичигдсэн. Цаасны хоёр тал тус бүр 20 босоо шугамтай, мөр бүрд 20 үг нарийн барлагдсан[4], зургууд тод гарсан. Гэхдээ олон жилийн өмнө хэвлэсэн Юань хэвлэл нь бүрэн бус болсон. Юань улс (1271-1368) нь Монгол угсаатны байгуулсан Монгол, Хятад, Солонгос улсуудын газар нутгийг эзлэн оршиж байсан феодалын нийгэмт хаант улс байсан юм. Тус улс нь Чингис хааны байгуулсан Их Монгол улсын үргэлжлэл тул түүхэн дэх хамгийн том газар нутагтай эзэнт гүрнийг удирдах төв нь байснаараа онцлогтой[5].

Хубилай өөрийгөө 1260 онд хаанд өргөмжилж, улмаар 1267 онд Монголын нийслэлийг Хар хорум хотоос Жунод (Дайд) (Одоогийн Бээжин хотын баруун хойд талд байсан) хотод шилжүүлсэн. Их Монгол улсын нэрийг 1271 онд өөрчилж, Юань хэмээн нэрийдсэнээр Монголын эзэнт гүрэн Алтан орд, Ил хаант улс, Цагаадайн улс, Юань улс гэсэн дөрвөн хаант улсад хуваагдсан.

Түүнчлэн XIII зууны үеийн Монголын Юань гүрний төр засгийн боловсрол гэгээрлийн дээд байгууллага болох Төрийн хөвгүүдийн сургууль одоогийн Бээжин хотын төв хэсэгт орших Дэнчин дүүргийн Аньдинмэн өргөн

чөлөөнд Гүезы-зень буюу Төрийн хөвгүүдийн гэгээрлийн яамны гудамжинд байрладаг байжээ[6].

Энэ үед Монголчуудын ардын эмчилгээ төгөлдөржин хөгжиж, бичиг үсгээр тэмдэглэгдэн, заан сургах, мөн бусад олон үндэстэн ястны анагаах ухаантай зэрэгцэн хөгжиж байжээ. Жишээ нь Юань гүрний үед хаадын зоог барих эмч түшмэл Монгол үндэстэн Хүсэхүйн зохиосон хоол, хүнс тэжээлийн эмчилгээний ном “Идээ ундааны жинхэнэ товч” 1330 онд Хятад хэлээр бичигдсэн[7] бөгөөд тэр нь Монгол төдийгүй Хятад гүрэнд идээ ундаагаар шимжүүлэн эмчлэх тухай ууган зохиол гэж хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Түүний доторх эхний боть, хоёрдох боть алдагдсан, гуравдах боть зөвхөн тодорхой хэсэг нь үлдсэн. Одоо Бээжингийн их сургуулийн номын санд хадгалагдаж байгаа[8].

Мин улсын үед Хятад хэлээр дахин хэвлэгдсэн байдаг. Энэ хэвлэлийг Дундад иргэн улсын 17-р оны үед (1469 он) сийлэн бичиж хэвлэсэн. Бээжингийн их сургуулийн номын сангийн зөвшөөрлөөр авчирч дармалдаж тараасан дэвтэр бий[9]. Энэ “Идээ ундааны жинхэнэ товч” одоогоор Хятад улсад ховор нандин номд тооцогддог. Бээжингийн Дундад улсын номын дэлгүүрээс 1985 онд “Идээ ундааны жинхэнэ товч”-ийг фото хуулбараар хэвлэсэн. Түүгээр “Хятад анагаах ухааны үдсэн онол”-ын нэгдүгээр боть болгосон. Мөн Хөхлуугийн орчуулгыг 1982 онд Өвөрмонголын ардын хэвлэлийн хорооноос Монгол хэлээр хэвлэсэн байдаг.

Япон, Америк, Хятад, Германы эрдэмтэд судалж зохиолын гол санаа хийгээд Хятад бус үг хэллэг, галиглаж бичсэн үг хэллэг зэргийн талаар өргөн хүрээтэй судалгааг хийсэн байна. Мөн Монголчуудын хамгийн өргөн хэрэглэж махан идээ болон тарваганы нэрийг галиглаж бичсэн нь сонирхолтой байдаг[8].

Мөн АУ-ы доктор, профессор Н.Төмөрбаатар[10] “Монголчуудын дорно дахины анагаах ухаанд оруулсан хувь нэмэр” судалгааны өгүүлэлдээ “Хүсэхүй эмчийн

амьдарч асан тухайн цаг үед Монголчууд шинэ улсыг байгуулж, хүн ардыг нь төвшитгөн захирч, удирдан жолоодохын тулд богино хугацаанд тухайн орны нөхцөл байдалд дасан зохицох шаардлага зүй ёсоор тавигдаж байжээ. Энэ үед Хүсэхүй “... хаан эзэн эрдэнийн сууринд сууснаас хойш төр гүрний хэргийг шийдвэрлэхэд түмэн яаруу байх тул идээ ундааг тохируулан, өвөг дээдсээс ямагт тогтсоор ирсэн бие махбодоо шимжүүлэн арчлах арга, ажил төрөл болон идээ ундааны амт чанарыг зүй зохистой тохируулах, сайтар анхаарваас богдод лагшин тунгалаг нэн амарлингуй болох буй за” хэмээсэн байдаг” хэмээн онцгойлон өгүүлжээ.

Хүсэхүй эмчийн энэ номыг хожим нь Япон, Солонгос, Тайланд зэрэг орнуудын эмнэлгийн сургуулиудад сурах бичиг болгон үзэх болсон[11] тухай судлаачид тэмдэглэсэн байдаг.

ДҮГНЭЛТ

Зохиолын өмнөх үгийн агуулгаас үзэхэд энэхүү номыг шинээр сэтгэн бичсэн бус Хубилай хааны үндэс суурийг нь тавьсан өвсөн эм болон идээ ундааны хэрэглээнд суурилан бичсэн бүтээл юм гэж үзэж болохоор байна.

Хятадын хаан, дээдсийн нэрээр аливаа зохиол бүтээлээ нэрлэдэг уламжлалыг даган Ли Шижэн нь “Идээ ундааны жинхэнэ товч”-ийг “Цэцэн” хэмээх цолыг хүртсэн Хубилайн алдраар нэрлэж “Хубилайн идээ ундааны жинхэнэ товч” ” (Hubilie yinshan zhengyao -忽必烈飲膳正要) гэж нэрлэсэн нь санамсаргүй хэрэг биш юм.

Номын нэрийн утгыг алдагдуулахгүйгээр салаа утга гарган хэрэглэж хүч оруулж, бодит нэр нь хувирах боловч агуулга, ухагдахууныг өөрчлөхгүйгээр зүйрлэх, солих, төлөөлөх аргаар салмал утга бүхий “Хубилайн идээ ундааны жинхэнэ товч” гэсэн нэр өгч уг нэрээрээ алдаршиж тухайн үеийн бүтээлүүдэд иш татагдаж ирсэн байна.

НОМ ЗҮЙ:

1. Ш.Болд, Х.Улаан-Од нарын орчуулга. “Идээ ундааны жинхэнэ товч” 1330 он (飲膳正要). Улаанбаатар, 2021 он. х – 23 – 30
2. Ш.Болд, Х.Улаан-Од нарын орчуулга. “Идээ ундааны жинхэнэ товч” 1330 он (飲膳正要) – академич Улаанбаатар, 2021 он. х-44-47
3. Surilaga. “Идээ ундааны жинхэнэ товч” – ийн зохиогчийн гарал үүсэл, номын оршилд хийсэн дүн шинжилгээ. “АЧ” АУИС, УБ, 2022. х – 45
4. [元] 忽思慧: «飲膳正要», 上海古籍出版社, 1990 版, 第5,10页. [Юань] Хүсэхүй, “Идээ ундааны жинхэнэ товч”. Шанхайн Эртний ном хэвлэлийн хороо. 1990 оны хувилбар. Х-5,10
5. 方春阳, 徐树明. 评我国古代营养学著作: 忽思慧 «飲膳正要». 中医杂志: 1982.第70 页. Fang Chunyang, Xu Shuming. Эртний хоол тэжээлийн ном “Хүсэхүйн Идээ ундааны жинхэнэ товч”-ийн талаарх сэтгэгдэл. Хятадын уламжлалт анагаах ухааны сэтгүүл. 1982 он, х-70
6. 徐旭升: 《中国古史的传说时代》, 文物出版社, 北京: 1985版, 第292页. Xu Xusheng. Эртний Хятадын түүхийн Домогт тайлбар, түүхийн дурсгалтын хэвлэлийн хороо. 1985 он. х-292
7. 白寿彝总主编, 陈得芝主编: 《中国通史元史卷》(总第八卷), 第557页. Bai Shouyi, Chen Dezhi: “БНХАУ-ын Юань гүрний түүх” (VIII боть), х-557
8. Урнаа.О /Wu Ri Na/. “Идээ ундааны жинхэнэ товч” зохирлын бүтэц, агуулга, орчуулгад хийсэн судалгаа. АУ-ы магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. 2017 он. х-14, 17
9. 徐仪明. 忽思慧其人其书及族属问题解析. 吉林师范大学学报: 2012. 第1页. Xu Yiming. Хүсэхүйн түүх болон номын судалгаа. Жилин хотын Багшийн их сургуулийн сэтгүүл. 2012 он. х-1
10. Н.Төмөрбаатар. “Монголчуудын дорно дахины анагаах ухаанд оруулсан зарим хувь нэмэр”. Монгол анагаах ухаан. 2010, 1(151): <http://www.mongolmed.mn/article/419>
11. Ш.Болд. “Монголын уламжлалт анагаах ухааны түүх”. УБ. 2006 х-143, 148

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор, профессор Э.Сэлэнгэ